

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2017 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги,  
зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр,  
бүтэц батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Засгийн газрын 2015 оны 144, 2016 оны 4, 2017 оны 76 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг нэгдүгээр, зохион байгуулалтын бүтцийг хоёрдугаар тус тус баталсугай.

2. Бүтэц шинэчлэн баталсантай холбогдуулан алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталж, 2017 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс мөрдүүлэхийг Цагдаагийн ерөнхий газрын дарга /С.Баатаржав/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Э.Энхтуяа/-т даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/55 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ц.НЯМДОРЖ

Хууль зүй, дотоод хэргийн сайдын  
2017 оны .... дугаар сарын ....-ны  
өдрийн .... дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

## ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

#### 1.1 Оршил

Энэхүү хөтөлбөрөөр Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн загварыг тодорхойлно.

Хөтөлбөр нь Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын агентлагуудын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн салшгүй хэсэг болно.

#### 1.2 Үндэслэл

Хөтөлбөр боловсруулахад дор дурдсан бичиг баримтыг үндэслэн удирдлага болгов. Үүнд:

- 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий цагдаагийн албаны тогтолцоо, үйл ажиллагаа, алба хаагчийн эрх зүйн байдлыг зохицуулах болсон.

- Цагдаагийн байгууллагад үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын зохистой харьцааг бий болгож, үйл ажиллагааг стандартад оруулах, дотоод болон хөндлөнгийн хяналтын тогтолцоог төлөвшүүлэх шаардлагатай гэж олон улсын шинжээчид дүгнэсэн.

- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн ерөнхий загварт нийцүүлэн Хууль зүй, дотоодын хэргийн сайд батлах эрх зүйн зохицуулалттай бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

- Цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлнэ.

Эдгээр нь Цагдаагийн ерөнхий газрын бүтэц, үйл ажиллагаанд хийх өөрчлөлтийг баталгаажуулах үндэслэл болж байна.

### 1.3 Цагдаагийн байгууллагын эрх зүйн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/;
- Төрийн албаны тухай хууль;
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль;
- Дотоодын цэргийн тухай хууль;
- Бусад хууль тогтоомж

### 1.4 Арга зүй

Хөтөлбөрийг стратегийн төлөвлөлтийн нийтлэг зарчим, арга зүйд үндэслэн дор дурдсан дарааллаар боловсруулав. Үүнд:

- Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн үндэслэл, шаардлагыг тодорхойлох;

- Цагдаагийн байгууллагын эрхэм зорилго, түүнд хүрэх арга зам, стратегийн зорилтыг тодорхойлох;

- Хөтөлбөрийн хүрэх үр дүнг тодорхойлох, тэдгээрийг хэмжих шалгуур үзүүлэлтийг боловсруулах

### 1.5 Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь

Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг буюу Цагдаагийн ерөнхий газар нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хууль тогтоомжоор хүлээлгэсэн захиргааны хяналтын үүргийг биелүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангахдаа иргэний эрх ашгийг дээдэлж, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратегийг баримтална.

Цагдаагийн байгууллага нь удирдлагын хэт төвлөрсөн бодлогоос татгалзаж, төв, орон нутгийн цагдаагийн байгууллага нь хариуцсан нутаг дэвсгэртээ хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, зөв зохистой удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэгтэй.

Цагдаагийн байгууллага нь өөрийн үйл ажиллагааны мэдээллийг нэгтгэн боловсруулж, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн сайдад гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангах үүрэг хүлээнэ.

### 1.6 Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Цагдаагийн байгууллагын стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч болон хэрэглэгч хамрагдана;

## ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР



Монгол Улсын Засгийн газар болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас цагдаагийн байгууллагатай харилцах хүрээнд цагдаагийн байгууллагын үндсэн хэрэглэгч нь Монгол Улсын Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Иргэний зөвлөл, аймаг, нийслэлийн Засаг дарга байна.

Цагдаагийн ерөнхий газар нь Цагдаагийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэл, журам, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу төрийн болон төрийн бус байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцана.

Цагдаагийн байгууллагын үйлчлүүлэгч нь дараах ангилалд хуваагдана. Үүнд:

### 1.Тодорхой хүрээнд:

- Цагдаагийн байгууллагаас харьяаллын дагуу шалгаж шийдвэрлэх зөрчилд ийн холбогдогч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч;

- Гэмт хэргийн улмаас хохирсон иргэн, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, хуулийн этгээд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчид;

- Цагдаагийн байгууллагад өргөдөл, гомдол, хүсэлт тавих болон бусад хэлбэрээр хандсан иргэн, хуулийн этгээд /хуульд заасны дагуу байгууллагаас

олгох гэрчилгээ, үнэмлэх, лавлагаа, тодорхойлолт, санал авах, тусламж хүссэн этгээд/

- Шаардлагатай тохиолдолд улсын онц чухал болон хүний амь нас, эрүүл мэнд, байгаль экологийн тэнцвэрт байдалд шууд хохирол учруулах эрсдэлтэй, гэмт халдлагад өртөж болзошгүй объект, ачаа тээшийг түр хамгаалах.

## 2.Нийтлэг хүрээнд:

- Иргэд, олон нийт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах ажиллагаанд олон нийтийг төлөөлөн оролцож байгаа олон нийтийн цагдаа, бусад оролцогч;

- Цагдаагийн байгууллагаас иргэд, олон нийтэд хүргэсэн ажил, үйлчилгээний тайланд үнэлэлт өгөх бүх шатны нутгийн өөрөө удирдах байгууллага, оршин суугч иргэд;

- Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд оролцож, дэмжлэг үзүүлж, хамтын ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд;

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль, Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасны дагуу явуулах гүйцэтгэх ажлын оролцогч тус тус хамаарна.

Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги

### 2.1 Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Цагдаагийн ерөнхий газрын бүтэц, үйл ажиллагааны стратегийн загварыг тодорхойлж, цагдаагийн ажил үйлчилгээг хууль ёсны дагуу чанартай, ил тод, хүртээмжтэй, шуурхай явуулахад чиглэсэн төлөвлөлт боловсруулахад үйл ажиллагааны стратегийн мөн чанар оршино.

### 2.2 Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Цагдаагийн ерөнхий газар нь дор дурдсан үйл ажиллагааг тэргүүлэх чиглэл болгож, мэргэжлийн удирдлагаар хангана. Үүнд:

- Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилсан сэргийлэх;
- Нийтийн хэв журам хамгаалах;
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах;
- Хуульд заасан захиргааны хяналтын үүрэг гүйцэтгэх.

### 2.3 Үйл ажиллагааны эрхэм зорилго

“Найдвартай, баталгаатай үйлчилгээ – иргэд, олон нийтийн итгэл, дэмжлэг”

### 2.4 Үйл ажиллагааны стратегийн зорилт

Цагдаагийн байгууллага үйл ажиллагааны эрхэм зорилгодоо хүрэхийн тулд дор дурдсан стратегийн зорилтыг хэрэгжүүлэх бөгөөд Цагдаагийн ерөнхий газар /түүний бүтцийн нэгж/ удирдлагаар хангаж, төлөвлөлт хийнэ. Үүнд:

- 2.4.1 Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлыг дээшлүүлэх;
- 2.4.2 Сайн удирдлага, зохион байгуулалтыг төлөвшүүлэх;
- 2.4.3 Мэргэшсэн үйл ажиллагаатай болох;

2.4.4 Эрүүл, чадварлаг хүний нөөц бүрдүүлэх;

2.4.5 Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтыг оновчтой төсөвлөж, хуваарилах;

2.4.6 Олон нийттэй /үйлчлүүлэгч, хэрэглэгчтэй/ харилцах /маркетинг/.

## 2.5 Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиллана

2.5.1 Стратегийн нэгдүгээр зорилтын хүрээнд:

2.5.1.1 цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлыг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.5.1.2 цагдаагийн сургалтын нэгдсэн төвийг түшиглэн алба хаагчдын харилцааны соёлыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулна.

2.5.1.3 цагдаагийн байгууллагын хүний нөөцийн сонгон шалгаруулалтад харилцааны соёлыг шалгуур үзүүлэлт болгоно.

2.5.1.4 цагдаагийн ажил, үйлчилгээний хүртээмж, чанар, шуурхай, соёлч байдлыг хангана.

2.5.1.5 жил бүр иргэд, олон нийтийн зүгээс цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлын талаарх судалгаа хийж, түүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээний талаарх бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.

2.5.2 Стратегийн хоёрдугаар зорилтын хүрээнд:

2.5.2.1 байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн болон эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлнэ.

2.5.2.2 цагдаагийн байгууллагад хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлнэ.

2.5.2.3 хууль тогтоомжоор нууцад хамааруулснаас бусад асуудлаар ил тод, нээлттэй тунгалаг байж, иргэний зөвлөл, олон нийттэй хамтран ажиллана.

2.5.2.4 шүүх эрх мэдлийн болон нутгийн удирдлагын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дэмжлэгтэйгээр хууль сахиулах, хуулийн хэрэгжилтийг хангах, нийгмийн хариуцлагыг төлөвшүүлэх чиглэлээр ажиллана.

2.5.2.5 цагдаагийн ажил, үйлчилгээг иргэд, олон нийтэд шуурхай, хүртээмжтэй хүргэнэ.

2.5.2.6 цагдаагийн албаны үйл ажиллагаанд эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнг ашиглаж, “Цагдаагийн инноваци” төсөл хэрэгжүүлнэ.

2.5.2.7 гадаад орны цагдаагийн байгууллагын тэргүүн туршлагаас суралцаж, үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.

2.5.2.8 байгууллагын дотоод соёл /сэтгэл зүй, үзэл хандлага, туршлага, итгэл үнэмшил, үнэт зүйл, өнгө төрх/-ыг төлөвшүүлнэ.

2.5.2.9 алба, алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтүүдийг чиг үүргийн онцлог, ажлын ачааллыг харгалзан үр дүнгээр нь тооцдог болно.

2.5.2.10 байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш шударгаар үйлчлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

2.5.2.11. Цагдаагийн байгууллагын дотоод холбоо, мэдээллийн систем болон бэлэн бус торгуулийн системийг цагдаагийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, цагдаагийн байгууллагын түргэн шуурхай, иргэдэд чирэгдэлгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.5.2.12. Хууль тогтоомжийг сурталчлах, сургалт зохион байгуулна.

2.5.2.13. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн талаар санал боловсруулна.

2.5.3 Стратегийн гуравдугаар зорилтын хүрээнд:

2.5.3.1 цагдаагийн албаны үйл ажиллагааг стандарт, арга зүй, аргачлалын дагуу явуулна.

2.5.3.2 цагдаагийн албаны үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, шударга, тэгш, хараат бус байх хэмжүүрийг бий болгон дагаж мөрдөнө.

2.5.3.3 мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа зөвхөн хууль ёсны, үндэслэлтэй нотлох баримтад тулгуурлана.

2.5.3.4 гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны стратеги, тактик арга зүйг эрдэм шинжилгээ, судалгаанд тулгуурлан, үндэслэлтэйгээр хөгжүүлж, үйл ажиллагаанд ашиглана.

2.5.3.5 цагдаагийн албаны үйл ажиллагаанд шаардлагатай мэдээлэл цуглуулах, шалгах, үнэлэн шинжлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх үйл ажиллагааг мэдээллийн технологийн хөгжилд тулгуурлан саадгүй, шуурхай зохион байгуулна.

2.5.3.6 цагдаагийн албаны үйл ажиллагаанд мэдээллийн технологийн ашиглалтыг нэмэгдүүлэх чиглэлээр "Цахим цагдаа" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.5.3.7. төрийн албаны тогтвортой байдлыг баталгаажуулж, албан хаагчдыг бэлтгэх, сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх танхимын болон зайн сургалтын хамрах хүрээг нэмэгдүүлж, төрийн албанд мэргэшсэн, чадварлаг байх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.5.3.8. мөнгө угаах, хүний наймаа, хар тамхины болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх.

2.5.4 Стратегийн дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

2.5.4.1 эрүүл мэнд-цагдаа төслийг хэрэгжүүлнэ.

2.5.4.2 цагдаагийн байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, үндсэн чиг үүргийн болон бусад чиглэлээр ажиллах хүний нөөцийн бүтцийн зохистой харьцааг бий болгоно.

2.5.4.3 цагдаагийн байгууллагын бүтэц, орон тоотой уялдуулан ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт, судалгаа, сонгон шалгаруулалт явуулж, томилолтын журмыг шинэчилж, тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн, мэргэшсэн, авьяас чадвартай, хүний нөөцийг бүрдүүлнэ.

2.5.4.4 цагдаагийн алба хаагчийг давтан сургах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, бүсчилсэн сургалтын төвүүдийг байгуулна.

2.5.4.5 манлайлах чадвар бүхий цагдаагийн удирдах ажилтан бэлтгэх бодлого баримтална.

2.5.4.6 цагдаагийн албанд төрийн албаны мерит буюу чадахуйн зарчмын тогтолцоог төлөвшүүлнэ.

2.5.4.7 цагдаагийн алба хаагч, ажилтны цалин хөлсийг нэмэгдүүлэх, нөхөн олговор, даатгалд хамруулах, мөнгөн урамшил, тусламж өгөх, амины орон сууцаар хангах зэрэг нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.5.4.8 алба хаагч, ажилтны хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцөлийг дээшлүүлнэ.

2.5.4.9. алба хаагч, ажилтнуудыг урт хугацааны, цогц даатгалд хамруулна.

2.5.4.10. алба хаагч, ажилтан бүрийг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэлтийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулна.

2.5.4.11. Монгол цагдааг хөгжүүлэх, цагдаа иргэдтэй хамтарч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

2.5.5 Стратегийн тавдугаар зорилтын хүрээнд:

2.5.5.1 төсөв, хөрөнгө оруулалтыг байгууллагын хөгжлийн стратеги төлөвлөгөө хэрэгжүүлж, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний бодит хэрэгцээнд тулгуурлан үндэслэлтэй оновчтой төсөвлөнө.

2.5.5.2 санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, төсөв захиран зарцуулагч нарт мэдлэг олгох, шилэн дансны тогтолцоог хөгжүүлнэ.

2.5.5.3 худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу явуулж, ил тод байдлыг хангана.

2.5.5.4 зардал, үр дүнгийн болон санхүүгийн шинжилгээг тогтмол хийж, үр ашиггүй зардал гаргахгүй ажиллана.

2.5.5.5. төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулна.

2.5.5.6. цагдаагийн алба хаагчийг орон сууцаар хангах хөтөлбөрийг батлуулж, хэрэгжүүлэх.

2.5.6 Стратегийн зургаадугаар зорилтын хүрээнд:

2.5.6.1 цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны маркетингийг иргэд, олон нийт, ялангуяа хүүхэд, залуучуудад чиглүүлж, тэдгээрээс хууль сахиулах үйл ажиллагаанд дэмжлэг авч хамтран ажиллана.

2.5.6.2 нэгэн ижил стандартын үйлчилгээний арга барил, зан харьцаа, барилга байгууламж, албаны автомашин, техник хэрэгсэл, дүрэмт хувцас зэргийг нэвтрүүлэх замаар гадаад өнгө төрхийг өөрчилнө.

2.5.6.3 цагдаагийн үйл ажиллагааны талаар олон нийтэд эрэлттэй мэдээллийн төрлийг судалж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэний санал, хүсэлтэд дүн шинжилгээ хийж, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээллээр туслах тогтолцоо бий болгоно.

2.5.6.4 байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс зохион байгуулж байгаа аливаа арга хэмжээ, үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагын оролцоог нэмэгдүүлж, харилцан ажиллагааны явцад байгууллагад шинээр нэвтрүүлсэн ажил, үйлчилгээний талаар сурталчилгаа явуулна.

2.5.6.5 олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон бусад эх сурвалжаас иргэдэд хүрч байгаа сөрөг мэдээллийг удирдах, хянах, нөлөөллийг бууруулах, бодитой, үнэн зөв мэдээллийг хүргэх арга хэмжээ авах байдлаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж, хэвшинэ.



2.5.6.6 цагдаагийн үйл ажиллагааны маркетинг удирдлагыг чанартай, шуурхай, соёлтой үйлчилгээг олон нийтийн итгэл дэмжлэг, иргэний хяналтад тулгуурлан хөгжүүлнэ.


2.5.6.7. аймаг, нийслэл, томоохон хот суурин газрын гудамж, талбайг камержуулж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд ашиглана.

## 2.6 Үйл ажиллагааны стратегийн загвар

Цагдаагийн төв байгууллагын үйл ажиллагааны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

### ЦАГДААГИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА (БИЗНЕС)-НЫ СТРАТЕГИЙН ЗАГВАР





### 3. Цагдаагийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үндсэн чиг үүрэг

3.1 Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дараах зарчмыг баримтлав. Үүнд:

- Цагдаагийн ерөнхий газрын стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх;
- Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх;
- Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх;
- Бүтцийн хувьд энгийн байх;

- Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох;
- Хангалттай чадавх, бодитой үйл ажиллагаа;
- Үйл ажиллагааны давхардалгүй байх;
- Улс төрөөс ангид байх;
- Нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх;

### 3.2 Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо

Дээр дурдсан зарчим болон Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги загварыг үндэслэн дараах бүтэцтэй байна. /Зохион байгуулалтын бүдүүвчийг хүснэгтээр хавсаргав/

### 3.3. Зохион байгуулалтын чиг үүрэг

3.3.1. Цагдаагийн ерөнхий газар нь цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх эрүүгийн цагдаа, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, замын цагдаагийн албатай.

Дээрх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай Эрүү, Мөрдөн байцаах, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, Тээврийн цагдаа, Санхүү, аж ахуйн, Санхүү, ар талын алба, Экологийн цагдаагийн алба, Захиргааны удирдлагын газар, нийтийн хэв журам хамгаалах газар, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газар, Интерполын үндэсний төв товчооны ажлын алба, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Мэдээллийн технологи, холбооны төв, Мэдээлэл, шуурхай удирдлагын газар, Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс, Хар тамхитай тэмцэх газар, Урьдчилан сэргийлэх газар, Бүртгэл хяналтын төв, Төлөвлөлт, зохион байгуулалтын, Хүний нөөц, сургалтын, Хуулийн, Гадаад харилцааны, Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын, Аюулгүй байдлын, Төрийн нууцын хэлтэс, Гадаад харилцаа, энхийг сахиулах ажиллагааны хэлтэс, Дотоод хяналт-аюулгүй байдлын, Зөрчлийн хэрэг бүртгэх газар, Зөрчлийн хэрэг бүртгэх алба, Хэвлэл мэдээллийн, Сургалтын нэгдсэн төв, Цагдаа, дотоодын цэргийн судалгааны төв, Шуурхай удирдлагын ажиллагааны хэлтэс, Төв архив, алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилт хариуцсан “Хүч” спортын хороо, урлаг, соёлын ажил хариуцсан “Сүлд чуулга” гэсэн нэгжтэй байна.

*/Энэ заалтад ХЗДХС-ын 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/09 тушаалаар нэмэлт орсон/ Хар тамхитай тэмцэх газар*

*/Энэ заалтад ХЗДХС-ын 2018 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/159 тушаалаар өөрчлөлт орсон/ Тээврийн цагдаагийн алба, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба*

*/Энэ заалтад ХЗДХС-ын 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/09 тушаалаар нэмэлт орсон/ Экологийн цагдаагийн алба*

*/Энэ заалтад ХЗДХС-ын 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/163 тушаалаар өөрчлөлт орсон/ Хэрэг бүртгэх гэснийг хассан*

*/Энэ заалтад ХЗДХС-ын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/114 тушаалаар өөрчлөлт орсон/ Зөрчлийн хэрэг бүртгэх газар, ДХАБГ, ГХЭСАХ*

*/Энэ заалтад ХЗДХС-ын 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн А/255 тушаалаар өөрчлөлт орсон/ Цагдаа, дотоодын цэргийн судалгааны төв, Шуурхай удирдлагын ажиллагааны хэлтэс*

*/Энэ заалтад ХЗДХС-ын 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/373 тушаалаар өөрчлөлт орсон/ Урьдчилан сэргийлэх газар*

*/Энэ заалтад ХЗДХС-ын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/392 тушаалаар өөрчлөлт орсон/ Зөрчлийн хэрэг бүртгэх алба, Санхүү, ар талын алба*

3.3.2. Эрүүгийн цагдаагийн алба нь нууц, далд аргаар үйлдэгдсэн болон тодорхой төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох ажиллагааг хариуцан зохион байгуулах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах. /Цагдаагийн албаны тухай хуулийн 6.5-д Цагдаагийн байгууллага нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх төрөлжсөн болон үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр мөрдөх, гүйцэтгэх ажил явуулах албатай байна/

3.3.3. Мөрдөн байцаах алба нь зөрчил шалган шийдвэрлэх болон эрүүгийн шийдвэрлэх тухай хуулиар харьяалуулсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах, мөрдөн шалгах ажиллагааг хариуцан явуулах, гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан нөхцөлийг тогтоож, арилгуулах зорилгоор иргэн, аж ахуйн нэгж байгууллагад мэдэгдэл өгч, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

*Энэ заалтад ХЗДХС-ын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/114 тушаалаар өөрчлөлт орсон/ зөрчил шалган шийдвэрлэх болон гэснийг хассан*

~~3.3.4. Хэрэг бүртгэх алба нь зөрчил шалган шийдвэрлэх болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиар харьяалуулсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах, хэрэг бүртгэх ажиллагааг хариуцан явуулах, гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан нөхцөлийг тогтоож, арилгуулах зорилгоор иргэн, аж ахуйн нэгж байгууллагад мэдэгдэл өгч, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.~~

*/Энэ заалтыг ХЗДХС-ын 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/163 тушаалаар хүчингүй болсонд тооцсон/*

3.3.5. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эргүүл, хамгаалалтын үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлэх бодлого, арга зүй, стандарт, зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, заавар, зөвлөмжийг боловсруулах, боловсронгуй болгох, эрүүлжүүлэх, саатуулах байрны үйл ажиллагаанд хяналт тавих, хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм, улс орны эрх ашигт ноцтой хор уршиг, хохирол учруулж болзошгүй аюулыг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд түшиглэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны бодлого, арга зүйг нэгтгэн зохион байгуулах, нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагаас зохион байгуулж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

3.3.5.1. энэ алба нь Нийтийн хэв журам хамгаалах газар, олон нийтийн аюулгүй байдлыг хангах газартай хэлтэстэй байна.

3.3.5.1.1. Нийтийн хэв журам хамгаалах газар нь хэлтэс нь зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, хуулиар харьяалуулсан зөрчлийг шалгаж шийдвэрлэх, байгууллага, алба хаагчийг мэдээллээр хангах, гудамж, талбай болон нийтийн эзэмшлийн бусад газарт эргүүл хийх, байнгын болон түр ажиллагаатай хянаж-нэвтрүүлэх цэг ажиллуулах дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, бусад арга, техник хэрэгсэл ашиглан хяналт тавих, замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, насанд

хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, гэрээт харуулын болон хувийн хамгаалалтын үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад илэрсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдэд шаардлага, сэрэмжлүүлэг өгөх, биелэлтийг нь хангуулах, олон нийтийн цагдааг мэргэжил, арга зүйгээр хангана.

3.3.5.1.2. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газар нь хэлтэс нь нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх бүх талын арга хэмжээ авах, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагааг гүйцэтгэх, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон, аюул үүссэн үед хорио цээрийн дэглэмийг сахиулах, амь нас, эрүүл мэнд нь онц аюултай нөхцөлд байгаа хүнд тусламж үзүүлэх, дипломат төлөөлөгчийн газрыг хамгаалах, шаардлагатай тохиолдолд улсын онц чухал болон хүний амь нас, эрүүл мэнд, байгаль экологийн тэнцвэрт байдалд шууд хохирол учруулах эрсдэлтэй болон гэмт халдлагад өртөж болзошгүй бусад объект, ачаа тээшийг түр хугацаагаар хамгаалах, төрийн тусгай хамгаалалтын хууль тогтоомжид заасан үүрэг гүйцэтгэх, нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал, цуглааны үеийн хамгаалалт хийх, яллагдагч, шүүгдэгч, ялтныг цагдан хорих байрнаас шүүх хуралдаанд авч ирэх, шүүх хуралдаанаас цагдан хорих байранд хуяглан хүргэх.

*/Энэ заалтад ХЗДХС-ын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/114 тушаалаар өөрчлөлт орсон/ газар гэснийг хэлтэс болгосон*

3.3.6.Тээврийн цагдаагийн алба нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах,төмөр зам, иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн газар, хэлтсийг харьяалан удирдах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

*/Энэ заалтад ХЗДХС-ын 2018 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/159 тушаалаар өөрчлөлт орсон/*

3.3.7. Захиргааны удирдлагын нэгж нь дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийн дагуу цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэхээр тусгагдсан ажил, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангах, биелэлт үр дүнг тооцох, тайлагнах, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангах, хууль сахиулах чиглэлээр баримтлах бодлого, үндсэн чиглэл, ойрын болон хэтийн зорилтыг тодорхойлох, хэрэгжилтийг ханга ажлыг зохион байгуулж. Байгууллагын удирдлагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хүний нөөцийн бодлого боловсруулж, алба хаагч ажилтныг сургаж бэлтгэх, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээг цагдаагийн байгууллагын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, алба хаагчийн хууль ёсны эрх, ашгийг хамгаалах, алба хаагчийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ тогтоосон баримт бичгийг Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсронгуй болгох, гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлийг боловсруулж, өргөжүүлэн хөгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.3.8.Тусгай /газар/ нэгж нь гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр цагдаагийн байгууллагын явуулах гүйцэтгэх ажлын тодорхой төрлийн арга хэмжээг хариуцан зохион байгуулах.

3.3.9.Тусгай ажиллагааны /газар/ нэгж нь Цагдаагийн байгууллагаас үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад тусгай тактик хэрэглэх, шаардлагатай үед Цагдаагийн ерөнхий газрын даргын шийдвэрээр тусгайлан бэлтгэгдсэн нэмэлт хүчээр мэргэжлийн туслалцаа үзүүлэх.

3.3.10.Интерполын үндэсний төв товчооны ажил хариуцсан нэгж нь олон улсын Эрүүгийн цагдаагийн байгууллага-Интерполын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, гадаад орны цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрээс хүлээн авсан мэдээ, мэдээллээр хангах, гэмт хэрэг үйлдээд оргон зайлсан этгээд, сураггүй алга болсон хүнийг олон улсын хэмжээнд эрэн сурвалжлах, гэмт хэрэг, гэмт этгээдийн талаар мэдээлэл солилцох.

3.3.11.Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба нь мэдээллийн сан бүрдүүлэх, цугларсан мэдээлэлд дүн шинжилгээ, судалгаа хийх, лавлагаа гаргах, гэмт хэрэгтэй тэмцэх, удирдлагын үйл ажиллагаанд шаардлагатай санал дүгнэлт, зөвлөмж, шийдвэрийн төсөл боловсруулах, цагдаагийн байгууллагын техник, технологийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, байгууллагын шуудан харилцаа, холбооны найдвартай, хэвийн ажиллагааг хангах, цагдаагийн тусгай дугаарын утсанд иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх.

*/Энэ заалтад ХЗДХС-ын 2018 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/159 тушаалаар өөрчлөлт орсон/*

*/Энэ заалтад ХЗДХС-ын 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн А/255 тушаалаар өөрчлөлт орсон/*

3.3.12.Мэдээллийн технологи, холбооны ажил хариуцсан нэгж нь цагдаагийн байгууллагын техник, технологийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах, байгууллагын шуудан харилцаа, холбооны найдвартай, хэвийн ажиллагааг хангах.

3.3.13.Мэдээлэл, шуурхай удирдлагын ажил хариуцсан нэгж нь цагдаагийн тусгай дугаарын утсанд иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, эрэн сурвалжлах, зарлан мэдээлэх үйл ажиллагааг цагдаагийн байгууллагын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, цагдаагийн төв байгууллагын удирдлагыг шаардлагатай мэдээллээр шуурхай хангах.

3.3.14.Гэрч, хохирогчийг хамгаалах ажил хариуцсан нэгж нь гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах ажлыг хариуцан зохион байгуулах.

3.3.15. Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан нэгж нь гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, хүүхдийн эрх, хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх, цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх ажлыг зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

*/Энэ заалтад ХЗДХС-ын 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/373 тушаалаар өөрчлөлт орсон/*

3.3.16.Бүртгэл, хяналт хариуцсан нэгж нь цагдаагийн байгууллагаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээг шуурхай хүргэх үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, зөвшөөрөл, бүртгэлийн нэгдсэн сан бүрдүүлэх.



3.3.17. Санхүү, ар талын нэгж нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө оруулалт, төсвийн тогтвортой байдлыг хангах бодлого боловсруулах, байгууллагын жилийн төвлөрсөн болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны төсөв, санхүүжилтийг хуваарилах, зарцуулалт, гүйцэтгэлд хяналт тавих, цагдаагийн байгууллага, алба хаагчийн ажил үүргээ хэвийн гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх, хангалт, үйлчилгээг зохион байгуулах.

Энэ нэгж нь үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, санхүүгийн болон хангамжийн, захиргааны нэгжтэй байна.

*/Энэ заалтад ХЗДХС-ын 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн А/255 тушаалаар өөрчлөлт орсон/*

*/Энэ заалтад ХЗДХС-ын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/392 тушаалаар өөрчлөлт орсон/*

3.3.17.1. Санхүүгийн нэгж нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө оруулалт, төсвийн тогтвортой байдлыг хангах бодлого боловсруулах, байгууллагын жилийн төвлөрсөн болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны төсөв, санхүүжилтийг хуваарилах, зарцуулалт, гүйцэтгэлд хяналт тавих.

3.3.17.2. Хангамжийн нэгж нь материал, техник, тусгай хангамжийн хувьд цагдаагийн байгууллага, алба хаагчийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлж, албаны хувцас, техник болон тусгай хэрэгсэл худалдан авах ажиллагааг хариуцан явуулж, дүрэмт хувцас, эд хэрэглэлийн хангалт, үйлчилгээг зохион байгуулах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах.

3.3.18. Төлөвлөлт, зохион байгуулалт хариуцсан нэгж нь Монгол Улсын хууль тогтоомж, дээд байгууллага, албан тушаалтны болон удирдлагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, туслалцаа үзүүлэх, байгууллагын хөгжлийн стратеги бодлого, үндсэн чиглэл, ойрын болон хэтийн зорилтыг тодорхойлж, түүнд нийцүүлэн байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцох, дээд шатны байгууллага, албан тушаалтныг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах.

3.3.19. Хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгж нь цагдаагийн байгууллагын хүний нөөц, сургалтын бодлогыг боловсруулах, мөрдүүлэх, алба хаагч, ажилтныг сургаж бэлтгэх, байгууллагын соёл, алба хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах.

3.3.20. Хуулийн асуудал хариуцсан нэгж нь хууль тогтоомжид нийцүүлэн цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ тогтоосон баримт бичгийг боловсронгуй болгох, хууль тогтоомж, эрхийн акт, шийдвэрийн төсөлд санал өгөх, эрх зүйн дүгнэлт гаргах, эрх зүйн актын нэгдсэн сан бүрдүүлэх, түгээх, байгууллага, алба хаагч, ажилтны хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн үед хууль зүйн зөвлөгөө өгөх, цагдаагийн байгууллагыг шүүхэд төлөөлөх ажлыг зохион байгуулах.

3.3.21. Гадаад харилцаа, энхийг сахиулах ажиллагаа хариуцсан нэгж нь гадаад орны хууль сахиулах байгууллага, олон улсын байгууллагатай харилцах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцаа тогтоох асуудлыг судлах, санал боловсруулах, шийдвэрлүүлэх, цагдаагийн байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг хангах, энхийг дэмжих ажиллагаа болон холбогдох сургалт, дадлагад оролцох алба хаагчийг сонгох, оролцуулах, бэлтгэл ажлыг хангах ажлыг зохион байгуулах.

*/Энэ заалтад ХЗДХС-ын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/114 тушаалаар өөрчлөн найруулсан/*

3.3.22.Архивын ажил хариуцсан нэгж нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн бичиг баримтыг архивын хууль тогтоомжийн дагуу хадгалах, хамгаалах, лавлагаа олгох, архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих ажлыг зохион байгуулах, цагдаагийн байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнуудыг мэргэжлийн удирдлагаар хангах.

3.3.23.“Хүч” спорт хороо нь цагдаагийн алба хаагчийн бие, бялдар, бэлтгэлжилтийн стандарт тогтоох, алба хаагчдын түвшинг тодорхойлох, бие бялдар бэлтгэлжилтийг зохих түвшинд нь хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээг хариуцан зохион байгуулах.

3.3.24. Дотоод хяналт-аюулгүй байдлын газар нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийж, үнэлгээ өгөх, цагдаагийн алба хаагч, ажилтанд холбогдох гомдол, мэдээллийг шалгаж, шийдвэрлүүлэх, цагдаагийн байгууллага, алба хаагч, ажилтан гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, судалгаа хийх, шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авч байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, төрийн болон байгууллагын нууцын хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, техник, криптографийн арга хэрэгсэл ашиглан шифр харилцааны үйл ажиллагааг удирдан зохион байгуулан мэдээ, мэдээллийн аюулгүй байдлыг хангах.

*/Энэ заалтад ХЗДХС-ын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/114 тушаалаар өөрчлөн найруулсан/*

3.3.25.Зөрчлийн хэрэг бүртгэх алба нь зөрчил шалган шийдвэрлэх хуулиар харьяалуулсан зөрчлийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагааг хариуцан явуулах, зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, зөрчил үйлдэгдсэн шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгуулах зорилгоор иргэн, аж ахуйн нэгж байгууллагад даалгавар хүргүүлэх, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулах, дүн шинжилгээ, судалгаа хийх, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах.

*/Энэ заалтад ХЗДХС-ын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/114 тушаалаар өөрчлөн найруулсан/*

*/Энэ заалтад ХЗДХС-ын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/392 тушаалаар өөрчлөлт орсон/*

~~3.3.26.Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс нь гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, хүүхдийн эрх, хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.~~

~~*/Энэ заалтад ХЗДХС-ын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/114 тушаалаар өөрчлөн найруулсан/*~~

~~*/Энэ заалтыг ХЗДХС-ын 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/373 тушаалаар хүчингүй болсонд тооцсон/*~~

~~3.3.27.Хэвлэл, мэдээлэл хариуцсан нэгж нь цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах бодлого боловсруулах, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх ажлыг зохион байгуулах.~~



*/Энэ заалтыг ХЗДХС-ын 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/373 тушаалаар хүчингүй болсонд тооцсон/*

3.3.28. Сургалт хариуцсан нэгж нь цагдаагийн алба хаагч, ажилтны мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалтын бодлого, хэрэгжүүлж, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, сургалт зохион явуулах.

3.3.29. “Сүлд” чуулга нь олон нийтэд түшиглэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, байгууллага, алба хаагчдын дунд урлаг, соёлын ажлыг хариуцан зохион байгуулах.

3.3.30. Дотоодын цэргийн штаб нь улсын онц чухал объектыг хамгаалах, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсоох, гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул тохиолдсон үед болон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардлагатай үед зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг харгалзан хүргэх, террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагаанд оролцох

Штаб нь дотоодын цэргийн хамгаалалтад авагдсан улсын онц чухал объектыг хамгаалах 2 анги, салбартай байна.

3.3.30.1. 05, 805 /анги, салбар/ нэгж нь улсын онц чухал болон хүний амь нас, эрүүл мэнд, байгаль экологийн тэнцвэрт байдалд шууд хохирол учруулах эрсдэлтэй болон гэмт халдлагад өртөж болзошгүй бусад объект, ачаа тээшийг түр хугацаагаар хамгаалах үүрэг гүйцэтгэх.

3.3.31. Хар тамхитай тэмцэх газар нь хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар олж авах, хадгалах, хэрэглэх, боловсруулах, бусдад худалдан борлуулахтай холбогдсон хэрэг, зөрчлийг илрүүлэх, мөрдөн шалгах, түүний шалтгаан нөхцөлийг арилгуулах, тухайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хариуцна.

*/Энэ заалтыг ХЗДХС-ын 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/09 тушаалаар нэмсэн/*

3.3.32. Экологийн цагдаагийн алба нь хүрээлэн байгаа орчныг хамгаалах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, байгаль экологид учрах хохирлыг бууруулах нэгдсэн бодлого хэрэгжүүлэх, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг ердийн болон онцгой нөхцөл байдал үүссэн үед шуурхай удирдлага, зохицуулалтад оруулах, алба хаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар, дээд шатны байгууллага, албан тушаалтныг бодит мэдээ, мэдээллээр хангах.

*/Энэ заалтыг ХЗДХС-ын 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/09 тушаалаар нэмсэн/*

3.3.33. Цагдаа, дотоодын цэргийн судалгааны төв нь цагдаа, дотоодын цэргийн байгууллагын чиг үүргээ хэрэгжүүлэх стандарт, дүрэм, журам, зааврыг боловсронгуй болгох чиглэлээр шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаа явуулах, инновацын бодлогыг тодорхойлох, улсын онц чухал объектын хамгаалалт, гэмт хэрэг, зөрчлийн ул мөр илрүүлэх, буулган авах, бэхжүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг нотлох, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, гүйцэтгэх ажил явуулах арга тактикийн чиглэлээр хийгдсэн судалгааны ажлын үр дүнг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх болон цагдаагийн төв байгууллагын даргын даалгасан асуудлаар судалгаа, боловсруулалт, туршилтын ажил эрхлэх,

дүн шинжилгээ хийх, байгууллагын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн шинэ мэдлэг, бүтээлч санааг эрэлхийлж, нээн гаргах хэрэглээнд нэвтрүүлэх, хариуцсан чиглэлээрээ цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах;

*/Энэ заалтыг ХЗДХС-ын 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн А/255 тушаалаар нэмсэн/*

3.3.34. Шуурхай удирдлагын ажиллагааны хэлтэс нь онцгой нөхцөл байдал үүссэн үед цагдаагийн байгууллагын хүч, хэрэгслийг шуурхай удирдлага, зохицуулалтаар хангаж, холбогдох хууль тогтоомж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тусгайлсан чиг үүргийн байгууллагуудтай харилцан мэдээ, мэдээлэл солилцох, хамтран ажиллах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага үйлдэгдсэн, онц байдал зарласан, байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гадаад орнуудын төрийн тэргүүн, дээд, өндөр хэмжээний зочид, төлөөлөгчдийн айлчлал, олон улсын дээд түвшний хурлын үед нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад нэгж, алба хаагчдыг холбох, харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах, эрэн сурвалжлах, зарлан мэдээлэх үйл ажиллагааг цагдаагийн байгууллагын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, эрх бүхий байгууллага, албан тушаалтныг мэдээллээр шуурхай хангах.

*/Энэ заалтыг ХЗДХС-ын 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн А/255 тушаалаар нэмсэн/*

--- оОо ---

## ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР

